



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ХОНГОР СУМЫН ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН  
ЗАХИРАГЧИЙН 2024 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНД ХИЙСЭН  
АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: ДАА-2025/2/НА-СТА-ТТЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу.



**Дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр**

Утас: 70373089 Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn

**Аудитын менежер У.Батсүрэн**

Утас: 70373089 Цахим хаяг: batsurenu@audit.gov.mn

**Ахлах аудитор С.Батцэцэг**

Утас: 70373089 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn

**Аудитор Н.Отгонцэцэг**

Утас: 70373089 Цахим хаяг: otgontsetsegn@audit.gov.mn

## **АГУУЛГА**

|  |    |
|--|----|
| 1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....                                      | 2  |
| 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....       | 4  |
| 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....                                   | 10 |
| 4. АУДИТЫН ТАЙЛАН .....  | 16 |
| 4.1 Ерөнхий зүйл .....   | 16 |
| 4.2 Материаллаг байдал .....   | 16 |
| 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....                        | 16 |
| 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ..... | 17 |
| 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....               | 17 |
| 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....   | 17 |
| 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....                       | 18 |

### **Товчилсон үгийн жагсаалт**

|          |  |
|----------|--|
| АДБОУС   | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт        |
| СХДАА    | Санхүү, хяналт дотоод аудитын алба                   |
| ЗДТГ     | Засаг даргын Тамгын газар                            |
| ИТХ      | Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал                         |
| НДШ      | Нийгмийн даатгалын шимтгэл                           |
| ОНӨААТҮГ | Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар |
| ОНХС     | Орон нутгийн хөгжлийн сан                            |
| ТЕЗ      | Төсвийн ерөнхийлөн захирагч                          |
| ТШЗ      | Төсвийн шууд захирагч                                |
| ХХС      | Хоршоо хөгжүүлэх сан                                 |
| ЭМТ      | Эрүүл мэндийн төв                                    |



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Бурхантын гудамж-1, 14 дүгээр баг, Дархан сум,  
Дархан-Уул аймаг, 45059,  
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089  
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

*О.О.О.О.* № *178*

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-т заасны дагуу Хонгор сумын ТЕЗ-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн нэгтгэсэн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Тус сумын орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилт 4,800.7 сая төгрөгөөр батлагдаж, хөрөнгийн зардал өмнөх оноос 3,255.2 сая төгрөгөөр буюу 2.9 дахин нэмэгдсэнийг санхүүгийн тайланд толилуулж, тодруулсан байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд төсвийн орлогын төлөвлөгөөг 924.3 сая төгрөгөөр буюу 8.6 хувиар давуулан биелүүлж, аймгийн төсөвт 5,187.6 сая төгрөг төвлөрүүлсэн байна.

**4525020309**

## **Бусад асуудлын хэсэг**

Төсвийн ерөнхийлөн захирагч бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Сумын Засаг даргын 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт, Хонгор сумын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг Хонгор сумын ИТХ-аар хэлэлцээд, 96.7 хувиар үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР




Ш.МӨНХБАЯР

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

| Код          | Үзүүлэлт   | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|--------------|--|----------------|-----------------|
| <b>1</b>     | <b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>                     | 2,597,069.8    | 4,755,256.5     |
| 31           | МӨНГӨН ХӨРӨНГӨ                                     | 1,836,128.5    | 1,837,346.7     |
| 33           | АВЛАГА   | 299,637.4      | 2,086,418.4     |
| 34           | УРЬДЧИЛГАА   | -              | 612.5           |
| 35           | БАРАА МАТЕРИАЛ                                     | 461,303.9      | 830,878.9       |
| <b>2</b>     | <b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>                 | 13,020,142.5   | 14,673,245.2    |
| 39           | ҮНДСЭН ХӨРӨНГӨ                                     | 13,020,142.5   | 14,673,245.2    |
| 39200        | Биет хөрөнгө                                       | 11,695,475.6   | 13,210,798.0    |
| 39300        | Биет бус хөрөнгө                                   | 1,324,666.8    | 1,462,447.1     |
| <b>3</b>     | <b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>                 | 15,617,212.3   | 19,428,501.6    |
| <b>4</b>     | <b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>                              | 218,032.1      | 268,774.9       |
| 41           | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР                          | 218,032.1      | 268,774.9       |
| 41300        | Өглөг  | 218,032.1      | 268,774.9       |
| <b>5</b>     | <b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>                    | 15,399,180.3   | 19,159,726.7    |
| <b>51</b>    | <b>Засгийн газрын хувь оролцоо</b>                 | 15,399,180.3   | 19,159,726.7    |
| 51100        | Засгийн газрын оруулсан капитал                    | 3,244,776.0    | 2,438,353.5     |
| 51101        | Өмч /төрийн/ /ТӨҮГ/                                |                | 945,252.5       |
| 51106        | Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/                   | 3,827,192.3    | 4,835,484.7     |
| <b>51200</b> | <b>Хуримтлагдсан үр дүн</b>                        | 7,015,659.5    | 9,629,083.6     |
| 51300        | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү                   | 1,311,552.4    | 1,311,552.4     |
| <b>6</b>     | <b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b> | 15,617,212.3   | 19,428,501.6    |



## 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

| Код        | Үзүүлэлт   | ӨМНӨХ ОН           | ТАЙЛАНТ ОН          |
|------------|--|--------------------|---------------------|
| <b>I</b>   | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>                   | <b>7,903,257.9</b> | <b>17,799,317.4</b> |
| <b>11</b>  | <b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>                                   | <b>5,183,326.6</b> | <b>9,880,815.7</b>  |
| 110        | Орлогын албан татвар                                     | 4,581,242.1        | 9,108,960.4         |
| 1100       | Хувь хүний орлогын албан татвар                          | 4,581,242.1        | 9,108,960.4         |
| 113        | Хөрөнгийн албан татвар                                   | 255,934.9          | 298,657.9           |
| 118        | Бусад татвар, төлбөр, хураамж                            | 346,149.6          | 473,197.4           |
| <b>12</b>  | <b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>                               | <b>1,082,352.1</b> | <b>1,185,297.6</b>  |
| 120        | Нийтлэг татварын бус орлого                              | 1,082,352.1        | 1,185,297.6         |
| <b>13</b>  | <b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>                     | <b>1,637,579.2</b> | <b>6,733,204.0</b>  |
| <b>II</b>  | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>                       | <b>6,256,523.8</b> | <b>12,684,266.0</b> |
| <b>21</b>  | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>                                     | <b>6,256,523.8</b> | <b>12,684,266.0</b> |
| <b>210</b> | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>                   | <b>3,921,542.9</b> | <b>6,047,126.8</b>  |
| 2101       | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил                        | 1,034,525.8        | 1,724,394.0         |
| 2102       | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл           | 131,664.4          | 216,435.3           |
| 2103       | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал                | 241,306.6          | 1,030,521.8         |
| 2104       | Хангамж, бараа материалын зардал                         | 153,795.8          | 180,419.0           |
| 2105       | Нормативт зардал   | 1,295.0            | 2,380.0             |
| 2106       | Эд хогшил, урсгал засварын зардал                        | 90,014.3           | 212,155.4           |
| 2107       | Томилолт, зочны зардал                                   | 9,850.6            | 14,920.0            |
| 2108       | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 220,189.4          | 621,462.7           |
| 2109       | Бараа үйлчилгээний бусад зардал                          | 2,038,900.9        | 2,044,438.5         |
| <b>213</b> | <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>                                  | <b>2,334,980.9</b> | <b>6,637,139.2</b>  |
| <b>22</b>  | <b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>                                  | <b>-</b>           | <b>-</b>            |
| <b>III</b> | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>             | <b>1,646,734.1</b> | <b>5,115,051.3</b>  |
| <b>IV</b>  | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>                   | <b>-</b>           | <b>-</b>            |
| <b>V</b>   | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>                   | <b>1,841,397.7</b> | <b>2,501,627.2</b>  |
| <b>VI</b>  | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>   | <b>(194,663.6)</b> | <b>2,613,424.1</b>  |

### 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт  | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн  | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|-----|---|---------------------------------|-----------------------|--------------------|--|
| 1   | 2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл           | 5,368,970.6                     | 1,311,552.5           | 7,210,323.0        | 13,890,846.1                           |
| 2   | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт      | -                               | -                     | -                  | -                                      |
| 3   | <b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>               | <b>5,368,970.6</b>              | <b>1,311,552.5</b>    | <b>7,210,323.0</b> | <b>13,890,846.1</b>                    |
| 4   | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | -                               | -                     | -                  | -                                      |
| 5   | Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт                  | 1,702,997.8                     | -                     | -                  | 1,702,997.8                            |
| 6   | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз   | -                               | -                     | -                  | -                                      |
| 7   | Өмчид гарсан өөрчлөлт                           | -                               | -                     | -                  | -                                      |
| 8   | Зарласан ногдол ашиг                            | -                               | -                     | -                  | -                                      |
| 9   | Тайлант үеийн үр дүн                            | -                               | -                     | (194,663.6)        | (194,663.6)                            |
| 10  | 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл           | 7,071,968.4                     | 1,311,552.5           | 7,015,659.4        | 15,399,180.3                           |
| 11  | 2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл             | 7,071,968.4                     | 1,311,552.5           | 7,015,659.4        | 15,399,180.3                           |
| 12  | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт      | -                               | -                     | -                  | -                                      |
| 13  | <b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>               | <b>7,071,968.4</b>              | <b>1,311,552.5</b>    | <b>7,015,659.4</b> | <b>15,399,180.3</b>                    |
| 14  | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | -                               | -                     | -                  | -                                      |
| 15  | Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт                  | 1,147,122.3                     | -                     | -                  | 1,147,122.3                            |
| 16  | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз   | -                               | -                     | -                  | -                                      |
| 17  | Өмчид гарсан өөрчлөлт                           | -                               | -                     | -                  | -                                      |
| 18  | Зарласан ногдол ашиг                            | -                               | -                     | -                  | -                                      |
| 19  | Тайлант үеийн үр дүн                            | -                               | -                     | 2,613,424.1        | 2,613,424.1                            |
| 20  | 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл           | 8,219,090.7                     | 1,311,552.5           | 9,629,083.5        | 19,159,726.7                           |



2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/


| Код         | Үзүүлэлт  | ӨМНӨХ ОН      | ТАЙЛАНТ ОН    |
|-------------|---|---------------|---------------|
| <b>I</b>    | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>                 | 8,198,744.1   | 16,224,227.1  |
| <b>11</b>   | <b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>  | 5,183,326.6   | 9,880,815.7   |
| 110         | Орлогын албан татвар  | 4,581,242.1   | 9,108,960.4   |
| 1100        | Хувь хүний орлогын албан татвар                               | 4,581,242.1   | 9,108,960.4   |
| <b>113</b>  | <b>Хөрөнгийн албан татвар</b>                                 | 255,934.9     | 298,657.9     |
| <b>118</b>  | <b>Бусад татвар, төлбөр, хураамж</b>                          | 346,149.6     | 473,197.4     |
| 1180        | Бусад нийтлэг төлбөр, хураамж                                 | 82,823.4      | 114,043.2     |
| 1181        | Газрын төлбөр   | 195,154.8     | 348,911.4     |
| 1182        | Байгалийн нөөц ашигласны төлбөр                               | 68,171.3      | 10,242.8      |
| <b>12</b>   | <b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>                                    | 1,338,882.9   | 1,496,688.8   |
| 120         | Нийтлэг татварын бус орлого                                   | 1,338,882.9   | 1,496,688.8   |
| <b>13</b>   | <b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>                          | 1,676,534.6   | 4,846,722.6   |
| <b>II</b>   | <b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>                      | 5,503,972.9   | 11,421,113.8  |
| <b>21</b>   | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>  | 5,503,972.9   | 11,421,113.8  |
| <b>210</b>  | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>                        | 2,982,262.7   | 4,775,260.8   |
| 2101        | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил                             | 1,144,875.8   | 1,998,174.2   |
| 2102        | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл                | 201,806.9     | 324,536.5     |
| 2103        | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал                     | 254,582.4     | 1,039,983.0   |
| 2104        | Хангамж, бараа материалын зардал                              | 354,695.9     | 471,010.0     |
| 2105        | Нормативт зардал  | 1,295.0       | 2,380.0       |
| 2106        | Эд хогшил, урсгал засварын зардал                             | 45,029.4      | 190,070.3     |
| 2107        | Томилолт, зочны зардал  | 9,084.6       | 13,655.0      |
| 2108        | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж      | 189,059.4     | 415,491.3     |
| 2109        | Бараа үйлчилгээний бусад зардал                               | 781,833.3     | 319,960.6     |
| <b>213</b>  | <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>                                       | 2,521,710.2   | 6,645,853.0   |
| <b>III</b>  | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>    | 2,694,771.3   | 4,803,113.3   |
| <b>V</b>    | <b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>              | 1,543,937.2   | 4,801,895.1   |
| <b>22</b>   | <b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>                                       | 1,543,937.2   | 4,801,895.1   |
| 2200        | Дотоод эх үүсвэрээр   | 1,543,937.2   | 4,801,895.1   |
| <b>VI</b>   | <b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>  | (1,543,937.2) | (4,801,895.1) |
| <b>VII</b>  | <b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН</b> | (238,600.0)   | -             |
| <b>23</b>   | <b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>             | 238,600.0     | -             |
| <b>VIII</b> | <b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>      | 912,234.1     | 1,218.2       |
|             | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл              | 923,894.4     | 1,836,128.5   |
|             | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл             | 1,836,128.5   | 1,837,346.7   |

ХТ05430 #9022699

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

| Код        | Үзүүлэлт   | Төлөвлөгөө          | Төсвийн гүйцэтгэлийн тайлан | Зөрүү                | Хувь  |
|------------|--|---------------------|-----------------------------|----------------------|-------|
| <b>II</b>  | <b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>                 | <b>12,870,165.6</b> | <b>9,296,802.1</b>          | <b>(3,573,363.5)</b> | 72.2  |
| <b>21</b>  | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>                                     | <b>5,219,826.7</b>  | <b>4,560,406.7</b>          | <b>(659,420.0)</b>   | 87.4  |
| <b>210</b> | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>                   | <b>3,842,565.7</b>  | <b>3,342,640.5</b>          | <b>(499,925.2)</b>   | 87.0  |
| 2101       | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил                        | 1,532,313.0         | 1,383,962.7                 | (148,350.3)          | 90.3  |
| 2102       | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл           | 191,539.4           | 171,852.6                   | (19,686.8)           | 89.7  |
| 2103       | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал                | 1,020,763.9         | 935,910.6                   | (84,853.3)           | 91.7  |
| 2104       | Хангамж, бараа материалын зардал                         | 116,287.1           | 116,244.2                   | (42.9)               | 100.0 |
| 2106       | Эд хогшил, урсгал засварын зардал                        | 2,406.7             | 2,380.0                     | (26.7)               | 98.9  |
| 2107       | Томилолт, зочны зардал                                   | 200,381.5           | 194,821.7                   | (5,559.8)            | 97.2  |
| 2108       | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 16,411.0            | 13,655.0                    | (2,756.0)            | 83.2  |
| 2109       | Бараа үйлчилгээний бусад зардал                          | 194,101.1           | 188,401.8                   | (5,699.3)            | 97.1  |
| 212        | <b>ТАТААС</b>  | <b>919,554.7</b>    | <b>919,554.7</b>            | -                    | 100.0 |
| 2121       | Төрийн өмчит байгууллагад олгох татаас                   | 919,554.7           | 919,554.7                   | -                    | 100.0 |
| <b>213</b> | <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>                                  | <b>457,706.3</b>    | <b>298,211.5</b>            | <b>(159,494.8)</b>   | 65.2  |
| 2131       | Засгийн газрын урсгал шилжүүлэг                          | 356,732.3           | 198,863.9                   | (157,868.4)          | 55.7  |
| 2132       | Бусад урсгал шилжүүлэг                                   | 100,974.0           | 99,347.6                    | (1,626.4)            | 98.4  |
| <b>22</b>  | <b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>                                  | <b>7,454,938.9</b>  | <b>4,736,395.4</b>          | <b>(2,718,543.5)</b> | 63.5  |
| <b>23</b>  | <b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>        | <b>195,400.0</b>    | -                           | <b>(195,400.0)</b>   | -     |
| <b>III</b> | <b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>                    | <b>12,870,165.6</b> | <b>9,545,077.4</b>          | <b>(3,325,088.2)</b> | 74.2  |
| 31         | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ                                  | 5,629,647.4         | 4,800,713.3                 | (828,934.1)          | 85.3  |
| 32         | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ                           | 5,955,249.6         | 4,609,610.3                 | (1,345,639.3)        | 77.4  |
| 35         | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС                    | 1,285,268.6         | 134,753.8                   | (1,150,514.8)        | 10.5  |
| 4          | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл         | -                   | 381,509.3                   | 381,509.3            |       |
| 5          | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл        | -                   | 629,784.7                   | 629,784.7            |       |



**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

/мянган төгрөгөөр/

| Код         | Үзүүлэлт   | Гүйцэтгэл       |
|-------------|--|-----------------|
| <b>II</b>   | <b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>   | <b>46,009.3</b> |
| <b>21</b>   | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>   | <b>46,009.3</b> |
| <b>210</b>  | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>   | <b>45,859.3</b> |
| 2101        | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил  | 7,080.0         |
| 2104        | Хангамж, бараа материалын зардал   | 16,417.3        |
| 2106        | Эд хогшил, урсгал засварын зардал  | 10,322.0        |
| 2108        | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж   | 9,000.0         |
| 2109        | Бараа үйлчилгээний бусад зардал  | 3,040.0         |
| 213         | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ   | 150.0           |
| <b>I</b>    | <b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>  | <b>46,009.3</b> |
| <b>1311</b> | <b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>   | <b>46,009.3</b> |
| -131104     | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 46,009.3        |



### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Хонгор сумын ТЭЗ нь харьяалах нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд төрийн захиргааны удирдлага, үйл ажиллагааг зохион байгуулалтаар ханган, иргэдэд төрийн үйлчилгээг хүргэх үйл ажиллагааг явуулах чиг үүргийн хүрээнд “Иргэдийн зохистой суурьшил, оршин суух таатай нөхцөлийг бүрдүүлсэн, инженерийн дэд бүтцийн хангамжийг нэмэгдүүлж, дэвшилтэд эко сум болгон хөгжүүлнэ” зорилтыг дэвшүүлэн ажилласан байна.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус сумын ТЭЗ нь Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам” зэргийг үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тайлант хугацаанд Төрийн албаны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль зэрэг үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг үр нөлөөтэй гэж тодорхойлон, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэх шаардлагагүй гэж үзсэн.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хонгор сумын ТЭЗ-ийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайланд нэгтгэсэн төсвийн шууд захирагч бүрийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

#### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хонгор сумын ТЭЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 3,811.3 сая төгрөгөөр буюу 24.4 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

| Үзүүлэлт       | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|----------------|----------------|-----------------|----------|
|                |                |                 |          |
| Мөнгөн хөрөнгө | 1,836.1        | 1,837.3         | 1.2      |
| Авлага         | 299.7          | 2,086.4         | 1,786.7  |

/сая төгрөгөөр/

|  |                 |                 |                |
|--|-----------------|-----------------|----------------|
| Урьдчилгаа                                   | 0.0             | 0.6             | 0.6            |
| Бараа материал                               | 461.3           | 830.9           | 369.6          |
| Үндсэн хөрөнгө                               | 13,020.1        | 14,673.2        | 1,653.1        |
| <b>Нийт хөрөнгө</b>                          | <b>15,617.2</b> | <b>19,428.5</b> | <b>3,811.3</b> |
| Өр төлбөр                                    | 218.0           | 268.8           | 50.8           |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/     | 15,399.2        | 19,159.7        | 3,760.5        |
| <b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b> | <b>15,617.2</b> | <b>19,428.5</b> | <b>3,811.3</b> |

Мөнгөн хөрөнгө 1.2 сая төгрөгөөр нэмэгдсэн нь орон нутгийн төсвийн орлого 924.3 сая төгрөгөөр буюу 8.6 хувиар давж биелсэн, төсөвт байгууллагууд оны эцэст 995.7 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн зэргээс шалтгаалжээ.

Харин авлагын данс 1,786.7 сая төгрөгөөр өссөн нь орон нутгийн хөгжлийн сангийн 1,890.2 сая төгрөгийн татаас санхүүжилтийн авлагатай холбоотой байна.

Урьдчилгаа дансанд “Эмт наран” ОНӨААТҮГ-ийн тендерийн баталгааны төлбөр 0.6 сая төгрөгийг байршуулсан байна.

Бараа материалын 369.6 сая төгрөгийн өсөлтөд төсвийн хөрөнгөөр 658.7 сая төгрөгийн материал худалдан авсан, 415.5 сая төгрөгийн материал хандиваар авсан, 704.6 сая төгрөгийн материалыг зарцуулсан нь нөлөөлжээ. Бараа материалын үлдэгдэлд сумын ЗДТГ-ын бусад хангамжийн материал, мал амьтад 82.5 хувийг эзэлж байна.

Үндсэн хөрөнгө 1,653.1 сая төгрөгөөр өссөн нь Хонгор сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 4,736.4 сая төгрөгийн хөрөнгийг эргэлтийн бус хөрөнгөд бүртгэсэнтэй холбоотой байна.

Өр төлбөр дансны өсөлтөд Хонгор сумын орон нутгийн хөгжлийн сангийн чанарын баталгааны өглөг 127.8 сая төгрөгөөр нэмэгдсэн нь нөлөөлжээ.

### 3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 1,837.3 сая төгрөг болж, өмнөх оноос 1.2 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл*

| Үзүүлэлт                     | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | /сая төгрөгөөр/<br>Өсөлт (+),<br>Бууралт (-) |
|------------------------------|----------------|-----------------|--|
| Кассад байгаа бэлэн мөнгө    | 0.0            | 0.0             | -  |
| Банканд байгаа бэлэн мөнгө   | 1,836.1        | 1,837.3         | 1.2  |
| <b>Төгрөг</b>                | <b>1,836.1</b> | <b>1,837.3</b>  | <b>1.2</b>                                   |
| Төрийн сангийн харилцах      | 1,815.6        | 1,543.2         | (272.4)                                      |
| Арилжааны банк дахь харилцах | 20.5           | 294.1           | 273.6  |
| <b>Дүн</b>                   | <b>1,836.1</b> | <b>1,837.3</b>  | <b>1.2</b>                                   |

*Эх сурвалж: Хонгор сумын ТЕЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Банкин дахь харилцах дансны үлдэгдэл 1,837.3 сая төгрөгийн 1,543.2 сая төгрөг нь төрийн сан дахь харилцах дансанд, 294.1 сая төгрөг нь арилжааны банканд байршиж байна.

Төрийн сангийн харилцахад байршиж буй 1,543.2 сая төгрөгийн 841.6 сая төгрөг нь сумын ерөнхий орлогын, 415.4 сая төгрөг нь орон нутгийн хөгжлийн сангийн, 214.4 сая төгрөг нь хоршоо хөгжүүлэх сангийн, 71.8 сая төгрөг нь байгаль орчны нөхөн сэргээлтийн барьцаа дансны үлдэгдэл байна. Харин “Эмт наран” ОНӨААТҮГ-ын 151.1 сая, “Хонгор хот тохижилт” ОНӨААТҮГ-ын 143.0 сая төгрөгийн үлдэгдэл арилжааны банк дахь харилцахад байршуулжээ.

**Аудитын илрүүлэлт:**

ТЕЗ-ийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар цалин хөлсийг илүү олгосон, шатахууны урамшууллыг санхүүгийн тайланд бүртгээгүй, анхан шатны баримтын бүрдэл хангаагүй баримтаар худалдан авалт хийсэн, ээлжийн амралтын олговрыг илүү тооцож олгосон зэрэг нийт 12.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн байна. Тухайлбал:

- Хонгор сумын ЗДТГ нь 18 албан хаагчид 1.5 сая төгрөгийн улирлын урамшууллыг нэмэгдсэн цалингаас тооцож олгосон, 3.1 сая төгрөгийн шатахууны урамшууллыг санхүүгийн тайланд бүртгээгүй, санхүүгийн ажилтнуудад 3.0 сая төгрөгийн үр дүнгийн мөнгөн урамшууллыг давхардуулан олгосон,
- Хонгор сумын “Эмт наран” ОНӨААТҮГ нь 4.6 сая төгрөгийн худалдан авалтын анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй,
- Хонгор сумын “Хонгор хот тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ нь 0.5 сая төгрөгийн ээлжийн амралтын олговрыг илүү олгосон байна.

**Шийдвэрлэсэн нь:** Дээрх зөрчлүүдээс 5.1 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 4.6 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж, 3.0 сая төгрөгийн зөрчилд таслан зогсоох албан шаардлагыг өгсөн.

### 3.4.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 2,086.4 сая төгрөг болж, өмнөх оноос 1,786.7 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

| Үзүүлэлт                        | Эхний үлдэгдэл | /сая төгрөгөөр/ |                        |
|---------------------------------|----------------|-----------------|------------------------|
|                                 |                | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
| Татаас санхүүжилтийн авлага     | 0.0            | 1,886.5         | 1,886.5                |
| Дансны авлага /ТӨҮГ/            | 60.5           | 57.3            | (3.2)                  |
| Татвар, НДШ-ийн авлага /ТӨҮГ/   | 0.6            | 0.5             | (0.1)                  |
| Ажиллагчидтай холбогдсон авлага | 1.3            | 0.0             | (1.3)                  |
| Байгууллагаас авах авлага       | 0.0            | 3.7             | 3.7                    |
| Хувь хүмүүсээс авах авлага      | 237.3          | 138.4           | (98.9)                 |
| Дүн                             | 299.7          | 2,086.4         | 1,786.7                |

Эх сурвалж: Хонгор сумын ТЕЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант оны эцэст авлага данс 1,786.7 сая төгрөгөөр өссөн нь орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 24 төсөл, арга хэмжээ бүрэн хэрэгжээгүйгээс дараа онд шилжсэн тул 1,890.2 сая төгрөгийн татаас санхүүжилтийн авлага бүртгэснээс шалтгаалжээ.

Нийт авлагын 90.6 хувийг орон нутгийн хөгжлийн сангийн авлага, 6.6 хувийг хоршоо хөгжүүлэх сангийн авлага, 2.8 хувийг ОНӨААТҮГ болон төсөвт байгууллагын авлага эзэлж байна.

**Аудитын илрүүлэлт:**

Авлага данстай холбоотой алдаа, зөрчил илрээгүй байна.

### 3.4.3 Урьдчилгаа

Хүснэгт 4. Урьдчилгаа

| Үзүүлэлт   | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | /сая төгрөгөөр/           |
|------------|----------------|-----------------|---------------------------|
|            |                |                 | Өсөлт (+),<br>Бууралт (-) |
| Урьдчилгаа | 0.0            | 0.6             | 0.6                       |
| <b>Дүн</b> | <b>0.0</b>     | <b>0.6</b>      | <b>0.6</b>                |

Эх сурвалж: Хонгор сумын ТЕЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урьдчилгаа дансанд тайлант онд 0.6 сая төгрөг нэмэгдсэн нь “Эмт наран” ОНӨААТҮГ-ийн тендерийн баталгааны төлбөр байршуулснаас шалтгаалжээ.

### 3.4.4 Бараа материал

Нэгтгэсэн тайланд бараа материалын эхний үлдэгдэл 461.3 сая төгрөг байснаас оны эцэст 830.8 сая төгрөг болж, 369.5 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл

| Үзүүлэлт                    | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | /сая төгрөгөөр/           |
|-----------------------------|----------------|-----------------|---------------------------|
|                             |                |                 | Өсөлт (+),<br>Бууралт (-) |
| <b>Хангамжийн материал</b>  | <b>461.3</b>   | <b>830.8</b>    | <b>369.5</b>              |
| Бичиг хэргийн материал      | 3.1            | 2.5             | (0.6)                     |
| Аж ахуйн материал           | 5.5            | 105.9           | 100.4                     |
| Сэлбэг хэрэгсэл             | -              | 1.6             | 1.6                       |
| Түлш, шатах тослох материал | 6.1            | 11.9            | 5.8                       |
| Барилгын засварын материал  | -              | 2.6             | 2.6                       |
| Бусад хангамжийн материал   | 331.9          | 424.4           | 92.5                      |
| Биологийн хөрөнгө           | 20.0           | 20.0            | 0.0                       |
| Мал амьтад                  | 94.7           | 261.9           | 167.2                     |
| <b>Дүн</b>                  | <b>461.3</b>   | <b>830.8</b>    | <b>369.5</b>              |

Эх сурвалж: Хонгор сумын ТЕЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын үлдэгдлийн 22.4 хувь нь ОНӨААТҮГ-т, 77.6 хувь нь төсөвт байгууллагад бүртгэлтэй байна. Бараа материал дансны өсөлтөд 658.7 сая төгрөгийн материал худалдан авсан, 415.5 сая төгрөгийн материал хандиваар авсан, 704.6 сая төгрөгийн материалыг зарцуулсан нь нөлөөлжээ. Бараа материалын үлдэгдэлд сумын ЗДТГ-ын бусад хангамжийн материал, мал амьтад 82.5 хувийг эзэлж байна.

#### Аудитын илрүүлэлт:

- Хонгор сумын ЗДТГ мал үржүүлгийн эхо аппаратыг 12.6 сая төгрөгөөр дутуу бүртгэсэн байсныг 12.6 сая төгрөгөөр тайланд тусгуулж,
- “Хонгор хот тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ нь үнэ төлбөргүй хүлээн авсан 109.5 сая төгрөгийн бараа материалыг орлого үр дүнгийн тайланд тайлагнасан байсныг эздийн өмчийн бусад хэсэг дансанд бүртгүүлж аудитын явцад тус тус залруулсан байна.

### 3.4.5 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 20,007.6 сая төгрөг болж, өмнөх оноос 3,134.1 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | /сая төгрөгөөр/           |
|----------|----------------|-----------------|---------------------------|
|          |                |                 | Өсөлт (+),<br>Бууралт (-) |

|                                  |                 |                 |                |
|----------------------------------|-----------------|-----------------|----------------|
| <b>Биет хөрөнгө</b>              | <b>15,547.2</b> | <b>18,542.5</b> | <b>2,995.3</b> |
| Барилга, байгууламж, орон сууц   | 5,786.7         | 5,752.6         | (34.1)         |
| Авто-тээврийн хэрэгсэл           | 980.4           | 924.7           | (55.7)         |
| Машин тоног төхөөрөмж(компьютер) | 1,255.5         | 1,599.7         | 344.2          |
| Тавилга, аж ахуйн эд хогшил      | 199.9           | 215.0           | 15.1           |
| Зам гүүрийн байгууламж           | 5,513.4         | 6,860.1         | 1,346.7        |
| Бусад үндсэн хөрөнгө             | 1,811.3         | 3,190.4         | 1,379.1        |
| <b>Биет бус хөрөнгө</b>          | <b>1,326.3</b>  | <b>1,465.1</b>  | <b>138.8</b>   |
| Программ хангамж                 | 13.0            | 13.0            | 0.0            |
| Бусад биет бус хөрөнгө           | 1,313.3         | 1,452.1         | 138.8          |
| <b>Дүн</b>                       | <b>16,873.5</b> | <b>20,007.6</b> | <b>3,134.1</b> |

Эх сурвалж: Хонгор сумын ТЕЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт үндсэн хөрөнгийн 73.2 хувь нь төсөвт байгууллагуудад, 26.8 хувь нь ОНӨААТҮГ-т бүртгэлтэй байна. Үндсэн хөрөнгийн нийт үлдэгдлийн 92.7 хувийг биет хөрөнгө, 7.3 хувийг бусад хөрөнгө эзэлж байна.

Үндсэн хөрөнгийн данс 3,134.1 сая төгрөгөөр өссөн нь Хонгор сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 4,736.4 сая төгрөгийн хөрөнгийг эргэлтийн бус хөрөнгөд бүртгэж, 1,680.7 сая төгрөгийн элэгдэл тооцсонтой холбоотойгоор нэмэгджээ.

**Аудитын илрүүлэлт:**

- Хонгор сумын ЗДТГ 1,162.3 сая төгрөгийн сумын төвийн гэрэлтүүлэг, авто замыг ангилал буруу бүртгэсэн, Хөрөнгийн гарз 7.4 сая төгрөгийг биет бус хөрөнгө худалдан авсан зардалд дансанд бүртгэсэн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Дээрх алдааг санхүүгийн тайланд залруулсан.

### 3.4.6 Өр төлбөр

Санхүүгийн нэгтгэсэн тайланд өр төлбөр дансны эхний үлдэгдэл 218.0 сая төгрөг байснаас оны эцэст 268.8 сая төгрөг болж, 50.8 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 8. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

| Үзүүлэлт                 | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | /сая төгрөгөөр/           |
|--------------------------|----------------|-----------------|---------------------------|
|                          |                |                 | Өсөлт (+),<br>Бууралт (-) |
| Байгууллагад төлөх өглөг | 114.1          | 219.1           | 105.0                     |
| Татварын өглөг /ТӨҮГ/    | 86.1           | 34.2            | (51.9)                    |
| Дансны өглөг /ТӨҮГ/      | 17.8           | 15.5            | (2.3)                     |
| <b>Дүн</b>               | <b>218.0</b>   | <b>268.8</b>    | <b>50.8</b>               |

Эх сурвалж: Хонгор сумын ТЕЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд Хонгор сумын орон нутгийн хөгжлийн сангийн чанарын баталгааны өглөг 127.8 сая төгрөгөөр нэмэгдсэн нь нөлөөлжээ.

**Аудитын илрүүлэлт:**

- “Хонгор хот тохижилт үйлчилгээ”ОНӨААТҮГ нь хог тээврийн 8.0 сая төгрөгийн орлогыг өглөг үүсгэхгүйгээр зарцуулсан тул аудитын явцад залруулсан байна.

### 3.4.7 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 19,159.8 сая төгрөг болж, өмнөх оноос 3,760.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 9. Засгийн газрын хувь оролцоо

/сая төгрөгөөр/

| Үзүүлэлт   | Эхний<br>үлдэгдэл | Эцсийн<br>үлдэгдэл | Өсөлт (+),<br>Бууралт (-) |
|--|-------------------|--------------------|---------------------------|
| Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ | 3,244.8           | 2,438.3            | (806.5)                   |
| Өмч /төрийн /  | -                 | 945.3              | 945.3                     |
| Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/                     | 3,827.2           | 4,835.5            | 1,008.3                   |
| <b>Хуримтлагдсан үр дүн</b>                          | <b>7,015.6</b>    | <b>9,629.1</b>     | <b>2,613.5</b>            |
| Өмнөх үеийн үр дүн                                   | 7,210.3           | 7,015.7            | (194.6)                   |
| Тайлант үеийн үр дүн                                 | (194.7)           | 2,613.4            | 2,418.7                   |
| Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү                     | 1,311.6           | 1,311.6            | 0.0                       |
| <b>Дүн</b>   | <b>15,399.2</b>   | <b>19,159.8</b>    | <b>3,760.6</b>            |

Эх сурвалж: Хонгор сумын ТЕЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 19,159.8 сая төгрөг болж 3,760.6 сая төгрөгөөр өссөн нь "Хонгор хот тохижилт" ОНӨААТҮГ-ын 857.2 сая төгрөгийн хөрөнгийн өсөлт болон тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

#### Аудитын илрүүлэлт:

"Хонгор хот тохижилт үйлчилгээ" ОНӨААТҮГ нь 792.9 сая төгрөгийн хөрөнгийг эздийн өмчид тусгаагүй байсныг аудитын явцад залруулсан байна.

### **3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус сумын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг ОНХС-ийн орлогыг 5,717.4 сая төгрөг, татварын болон татварын бус орлогыг 5,983.7 сая төгрөг, хөршоо хөгжүүлэх сангийн үлдэгдэл 200.4 сая төгрөг, урьд оны үлдэгдэл 949.3 сая төгрөг, нийт зарлагыг 10,238.3 сая төгрөг, аймгийн төсөвт төвлөрүүлэх 2,612.5 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснийг сумын ИТХ хэвээр баталсан байна.

#### **3.5.2 Төсвийн гүйцэтгэл**

Батлагдсан төсвийг тайлант хугацаанд 1 удаа зохицуулалт хийж, 1 удаа тодотгож, санхүүжих эх үүсвэр болон зарлагыг 2,631.8 сая төгрөгөөр нэмэгдүүлж, нийт 12,870.1 сая төгрөгөөр тодотгосон байна. Тодотголоор урьд оны үлдэгдлийг 357.0 сая төгрөгөөр, татварын болон татварын бус орлогыг 3,524.7 сая төгрөгөөр, ОНХС-ийн хөрөнгөөр гүйцэтгэх төсөл арга хэмжээг 1,325.3 сая төгрөгөөр нэмэгдүүлэн, урсгал зардалд 2,631.8 сая төгрөг, аймгийн төсөвт төвлөрүүлэх зардлыг 2,575.2 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлжээ.

Гүйцэтгэлээр ОНХС-аас 4,800.7 сая төгрөгийн санхүүжилт авч, орон нутгийн төсвийн орлогоор 4,609.6 сая төгрөг, үйл ажиллагааны орлогоор 134.7 сая төгрөгийн орлого бүрдүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 9,296.8 сая төгрөг буюу 72.2 хувьтай байгаа нь сумын ЗДТГ-т орон тоо дутуу ажилласнаар цалин, НДШ-ийн зардал 153.2 сая, Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн зардлаас санхүүжүүлэх 12 төсөл, арга хэмжээг дараа онд шилжүүлсэнтэй холбоотойгоор бараа үйлчилгээний бусад зардлаас 231.7 сая төгрөгийг зарцуулаагүй, ХХС-ийн 195.4 сая төгрөгийн зээл олгогдоогүй, ОНХС-ийн 2,226.5 сая төгрөгийн 24 төсөл, арга хэмжээ он дамжин хэрэгжиж байгаа зэргээс тус тус шалтгаалжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.5.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Хонгор сумын ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд Дархан-Уул аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газраас үлийн цагаан оготноос урьдчилан сэргийлэх зардалд 29.1 сая, Статистикийн хэлтсээс мал тооллоготой холбоотой зардалд 2.5 сая, ИТХ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд гэмт хэргээс урьдчилсан сэргийлэх үйл ажиллагааны зардалд 14.4 сая, нийт 46.0 сая төгрөгийн орлого төвлөрч зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Хонгор сумын ТЕЗ-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн сумын ИТХ-ын суудалтай намуудад олгосон дэмжлэгтэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Н.Отгонцэцэг гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор С.Батцэцэг, аудитын менежер У.Батсүрэн, дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Хонгор сумын Засаг дарга 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 01/155 тоот албан бичгээр 2025 оны 03 дугаар сарын 05-ны өдөр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр ТЕЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн нийт хөрөнгийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны нийт хөрөнгө 19,159.4 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 291.4 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой алдаа, зөрчил илрээгүй болно.

#### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Хонгор сумын ТЕЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд завсрын аудит хийгээгүй болно.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар цалин хөлстэй холбоотой 1 зөвлөмж өгснийг биелүүлсэн байна.

Хүснэгт 12. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

| Үзүүлэлт | Өмнөх аудитаар |     | Биелэлт |     |      |
|----------|----------------|-----|---------|-----|------|
|          | Тоо            | Дүн | Тоо     | Дүн | Хувь |
| Зөвлөмж  | 1              | 3.3 | 1       | 3.3 | 100  |
| Нийт дүн | 1              | 3.3 | 1       | 3.3 | 100  |

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 2,670.6 сая төгрөгийн 3 алдаа<sup>1</sup> илэрснийг аудитын явцад залрууллаа. Үүнд:

- “Э-тайлан” цахим системд цалин хөлс түүнтэй адилтгах орлогын албан татварын орлогын төлөвлөгөөг 79.6 сая төгрөгөөр дутуу илэрхийлсэн нь УСНББОУС 1 “Санхүүгийн тайлангийн толилуулга”, “Толилуулга” батламж мэдэгдлийг хангаагүй тул “э-тайлан” цахим системд нэмж залруулав.

- Санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайланд 1,645.7 сая төгрөгийн үйл ажиллагааны орлогыг дутуу илэрхийлсэн нь УСНББОУС 1 “Санхүүгийн тайлангийн толилуулга”, “Толилуулга” батламж мэдэгдлийг хангаагүй тул санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн үйл ажиллагааны орлогыг нэмж тусган залруулав.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

- Санхүүгийн байдлын нэгтгэсэн тайланд “Эмт наран” ОНӨААТҮГ-н өмчийг ангилал зөрүүлэн бүртгэсэн нь УСНББОУС 1 “Санхүүгийн тайлангийн толилуулга”, “Ангилал” батламж мэдэгдлийг хангаагүй тул санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлангийн өмч /ТӨҮГ/ ангилалд тусган залруулав.

Аудитаар сумын ИТХ-д суудалтай намуудад орон нутгийн төсвөөс дэмжлэг олгосон зөрчил<sup>2</sup> илэрсэнд зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүлэв.

### 5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоох зөрчилтэй асуудал гараагүй болно.

### 5.2 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага өгөх зөрчилтэй асуудал гараагүй болно.

### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. ИТХ-д суудалтай намуудад орон нутгийн төсвөөс дэмжлэг олгосонтой холбоотой асуудал

##### 1.1. Илрүүлэлт:

Тус сумын ИТХ-д суудалтай намуудад орон нутгийн төсвөөс 27.0 сая төгрөгийн дэмжлэг олгосон байна. Энэ нь Улс төрийн намын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5-т “энэ хуулийн 34.6-д заасан хориглосон этгээдээс хандив, тусламж, санхүүжилт шууд болон шууд бусаар авах”; 34 дүгээр зүйлийн 34.6-д “нам дараах этгээдээс хандив авахыг хориглоно”, 34.6.3-т “төрийн байгууллага болон нутгийн өөрөөр удирдах байгууллага” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

##### 1.2. Өгсөн зөвлөмж:

Улс төрийн намын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5, 34 дүгээр зүйлийн 34.6.3 дахь заалтыг баримталж, аудитын тайлан хүргүүлсэн өдрөөс хойш орон нутгийн төсвөөс ИТХ-д суудалтай намуудад санхүүгийн дэмжлэг олгохгүй байх

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5<sup>3</sup>-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

| Байгууллагын нэр | Нийт алдаа | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | Буруу тусган илэрхийлсэн | /сая төгрөгөөр/ |              |         |     |
|------------------|------------|-----------------------------------|--------------------------|-----------------|--------------|---------|-----|
|                  |            |                                   |                          | Үүнээс          |              | Зөвлөмж |     |
|                  |            |                                   |                          | Залруулсан      | Залруулаагүй | Тоо     | Дүн |
|                  |            |                                   |                          |                 |              | Тоо     | Дүн |

<sup>2</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

<sup>3</sup> Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

|                                |          |                |          |          |          |                |          |                |          |          |          |          |
|--------------------------------|----------|----------------|----------|----------|----------|----------------|----------|----------------|----------|----------|----------|----------|
| ЗДТГ                           | 1        | 1,182.3        | -        | -        | 1        | 1,182.3        | 1        | 1,182.3        | -        | -        | -        | -        |
| "Хонгор хот тохижилт" ОНӨААТҮГ | 4        | 1,030.8        | -        | -        | 4        | 1,030.8        | 4        | 1,030.8        |          |          |          |          |
| ТЕЗ                            | 3        | 2,670.5        | -        | -        | 3        | 2,670.5        | 3        | 2,670.5        |          |          |          |          |
| <b>Дүн</b>                     | <b>8</b> | <b>4,883.6</b> | <b>-</b> | <b>-</b> | <b>8</b> | <b>4,883.6</b> | <b>8</b> | <b>4,883.6</b> | <b>-</b> | <b>-</b> | <b>-</b> | <b>-</b> |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

| Байгууллагын нэр               | Нийт зөрчил |             | /сая төгрөгөөр/<br>Үүнээс |            |                 |            |          |             |                                      |          |   |          |
|--------------------------------|-------------|-------------|---------------------------|------------|-----------------|------------|----------|-------------|--------------------------------------|----------|---|----------|
|                                |             |             | Төлбөрийн акт             |            | Албан шаардлага |            | Зөвлөмж  |             | Хариуцлага тооцуулах албан шаардлага |          | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал |          |
|                                | Тоо         | Дүн         | Тоо                       | Дүн        | Тоо             | Дүн        | Тоо      | Дүн         | Тоо                                  | Дүн      | Тоо   | Дүн      |
| ЗДТГ                           | 3           | 7.6         | 2                         | 4.6        | 1               | 3.0        |          |             | -                                    | -        | -   | -        |
| ИТХ                            | 1           | -           | -                         | -          | -               | -          | 1        | -           | -                                    | -        | -   | -        |
| "Хонгор хот тохижилт" ОНӨААТҮГ | 1           | 0.5         | 1                         | 0.5        | -               | -          | -        | -           | -                                    | -        | -   | -        |
| "Эмт наран" ОНӨААТҮГ           | 1           | 4.6         |                           |            |                 |            | 1        | 4.6         |                                      |          |   |          |
| ТЕЗ                            | 1           | 27.0        |                           |            |                 |            | 1        | 27.0        |                                      |          |   |          |
| <b>Дүн</b>                     | <b>7</b>    | <b>39.7</b> | <b>3</b>                  | <b>5.1</b> | <b>1</b>        | <b>3.0</b> | <b>3</b> | <b>31.6</b> | <b>-</b>                             | <b>-</b> | <b>-</b>  | <b>-</b> |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

| Байгууллагын нэр  | Нийт зөрчил |                | /сая төгрөгөөр/<br>Үүнээс |          |                 |          |          |                |
|---|-------------|----------------|---------------------------|----------|-----------------|----------|----------|----------------|
|   |             |                | Төлбөрийн акт             |          | Албан шаардлага |          | Зөвлөмж  |                |
|   | Тоо         | Дүн            | Тоо                       | Дүн      | Тоо             | Дүн      | Тоо      | Дүн            |
| <b>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</b> |             |                |                           |          |                 |          |          |                |
| ЗДТГ  | 1           | 2,614.5        |                           |          |                 |          | 1        | 2,614.5        |
| "Эмт наран" ОНӨААТҮГ  | 1           | 2,545.0        |                           |          |                 |          | 1        | 2,545.0        |
| <b>Дүн</b>  | <b>2</b>    | <b>5,159.5</b> | <b>-</b>                  | <b>-</b> | <b>-</b>        | <b>-</b> | <b>2</b> | <b>5,159.5</b> |
| <b>Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил</b>                 |             |                |                           |          |                 |          |          |                |
| "Эмт наран" ОНӨААТҮГ  | 1           | -              |                           |          |                 |          | 1        | -              |
| <b>Дүн</b>  | <b>1</b>    | <b>-</b>       |                           |          |                 |          | <b>1</b> | <b>-</b>       |
| <b>Нийт дүн</b>   | <b>3</b>    | <b>5,159.5</b> |                           |          |                 | <b>3</b> | <b>-</b> | <b>5,159.5</b> |

**Долоо. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

| №        | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо |                             |                    | Санал дүгнэлтийн хэлбэр |           |                |          |                            |
|----------|-----------------------------|--------------------------|-----------------------------|--------------------|-------------------------|-----------|----------------|----------|----------------------------|
|          |                             | Аудитад хамрагдах        | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр |                    |                         | Зөрчилгүй | Хязгаарлалттай | Сөрөг    | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
|          |                             |                          | Санал дүгнэлт гаргасан      | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй         |           |                |          |                            |
| <b>A</b> | <b>1</b>                    | <b>2</b>                 | <b>3</b>                    | <b>4</b>           | <b>5</b>                | <b>7</b>  | <b>8</b>       | <b>9</b> | <b>10</b>                  |
| 1        | ТШЗ                         | 4                        | 3                           | 1                  |                         | 3         |                |          |                            |
| 2        | Төсөл, хөтөлбөр             |                          |                             |                    |                         |           |                |          |                            |
| 3        | ЗГТС                        |                          |                             |                    |                         |           |                |          |                            |
| 4        | ОНӨҮГ                       | 2                        | 2                           |                    |                         | 2         |                |          |                            |
| 5        | ТЕЗ                         | 1                        | 1                           |                    |                         | 1         |                |          |                            |
|          | <b>НИЙТ</b>                 | <b>7</b>                 | <b>6</b>                    | <b>1</b>           |                         | <b>6</b>  |                |          |                            |